



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/113

Хэрлэн сум

Урамшуулал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Засгийн газрын "Төрийн албан хаагчид нэмэгдэл олгох журам батлах тухай" 1995 оны 06 дугаар сарын 14-ний 96 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид шагнал, урамшил олгох журам"-ын 5, 9 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн сайдын 2013 оны 266 дугаар тушаалаар батлагдсан "Өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулах гүйцэтгэлийн гэрээ"-ний дагуу аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний 8.4, 8.7 дахь заалтын дагуу 2016 оны үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргээ "А" буюу бүрэн хангалттай үнэлүүлсэн "Хэрлэн дом" өрхийн эрүүл мэндийн төвийн дарга Ж.Хонгорзул, "Ач манал" өрхийн эрүүл мэндийн төвийн дарга Ч.Уранцэцэг, "Оюуны шим" өрхийн эрүүл мэндийн төвийн дарга Г.Цэнд нарыг сарын цалингийн 40 хувиар урамшуулсугай.

2. Цалингийн урамшууллыг байгууллагын төсвийн хэмнэлт, өөрийн орлогоос тооцож олгохыг "Хэрлэн дом", "Ач манал", "Оюуны шим" өрхийн эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч /Н.Алтансүвд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Г.Лхагвахатан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 566